



**НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2015 оны 05 сарын 22 өдөр

Дугаар А/ҮӨ


Улаанбаатар хот

Дүрэм шинэчлэн батлах тухай

Нийгмийн даатгалын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, 29 дүгээр зүйл, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Засгийн газрын 2015 оны “Дүрэм шинэчлэн батлах тухай” 11 тоот тогтоолоор батлагдсан “Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрэм”-ийн 4 дэх хэсгийн 4.2, Засгийн газрын 2014 оны “Дүрэм, журам батлах тухай” 354 тоот тогтоолоор батлагдсан “Нийгмийн даатгалын байцаагчийн дүрэм”-ийн 2 дугаар зүйлийн 2.1.3 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. “Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын магадлагч эмчийн дүрэм”-ийг хавсралт ёсоор баталсугай.
2. Магадлагч эмчийг орон тоогоор ажиллуулж, удирдлага арга зүйгээр хангаж ажиллахыг Аймаг (дүүрэг)-ийн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга нарт үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комисс /П.Мөнхтулга/-т даалгасугай.
4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2004 оны “Магадлагч эмчийг орон тоогоор ажиллуулах тухай” 26 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Ц.УРТНАСАН

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын
2015 оны 05 дугаар сарын 22 -ны өдрийн
А/Т/О тоот тушаалын хавсралт



ЭМНЭЛЭГ ХӨДӨЛМӨРИЙН МАГАДЛАЛЫН МАГАДЛАГЧ ЭМЧИЙН ДҮРЭМ

Нэг.Нийтлэг үндэслэл

- 1.1. Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын магадлагч эмч /цаашид “Магадлагч эмч” гэх/ нь даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоох, хөдөлмөр зохицуулалт хийх, эмнэлгийн хуудасны бичилт, олголт, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний сувиллын сэргээн засах тусламж үйлчилгээний чанар, хүртээмж, эмнэлэг хяналтын комисс болон эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын үйл ажиллагаанд хяналт тавих зэрэг үндсэн чиг үүрэгтэй ажиллана.
- 1.2. Магадлагч эмч нь үйл ажиллагаандаа Нийгмийн даатгалын тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, Эрүүл ахуйн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрэм болон бусад эрх зүйн актыг мөрдлөг болгоно.
- 1.3. Нийгмийн даатгалын байгууллага нь эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын байгууллагад 3-аас доошгүй жил ажилласан, хүний их эмч мэргэжилтэй, эрхэлсэн ажлын дадлага туршлагатай эмч, мэргэжилтнийг тухайн Нийгмийн даатгалын хэлтсийн даргын тушаалаар магадлагч эмчээр томилон, үр дүнгийн гэрээ байгуулж ажиллана.
- 1.4. Магадлагч эмч нь энэхүү дүрмийн 1.1-д заасан үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэн, нийгмийн даатгалын болон эмнэлгийн байгууллагын хооронд үүсэх харилцаанд дотоодын хяналт тавьж, даатгуулагчийн эрх ашгийг хамгаалан ажиллана.
- 1.5. Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комиссын магадлагч эмч нь Хөдөлмөрийн эрүүл мэнд судлалын төв, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын бүрэлдэхүүнд ажиллана.

Хоёр. Магадлагч эмчийн эрх

Магадлагч эмч нь дараахь эрхийг эдэлнэ. Үүнд:

- 2.1. Эмнэлэг хөдөлмөрийн магадлал, эмнэлгийн хуудасны бичилт, олголтын талаар хууль тогтоомжид заасан эрхийн дагуу аж ахуйн нэгж байгууллага, эрүүл мэндийн байгууллагуудад хяналт шалгалт хийх, тайлбар, лавлагаа гаргуулан авах;
- 2.2. Даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдсан шалтгаан, нөхцөл, хувь хэмжээ, хугацаа, хөдөлмөрийн тусгай нөхцөл тогтоолгох асуудлаар дараах бичиг баримт гаргуулан авах. Үүнд:
 - 2.2.1. Ажил олгогчоос даатгуулагчийн ажил мэргэжил, хөдөлмөрийн нөхцлийн тухай тодорхойлолт;
 - 2.2.2. Эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ, оношлогоо болон эмчлэн эрүүлжүүлэх төлөвлөгөө, сэргээн засах эмчилгээ, эмчийн хяналтын талаарх лавлагаа, дүгнэлт;
- 2.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэврийн хувийн хэрэг, бичиг баримтын бүрдэл, эмнэлэг хяналтын комиссын шийдвэр, эмнэлгийн хяналтын карт зэргийг шалгаж илэрсэн зөрчлийг арилгуулах;
- 2.4. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хуралд оролцоогүй, комиссын болон эмчлэгч эмчийн эмчилгээ, үйлчилгээний зөвлөмж зааврыг удаа дараа биелүүлээгүй, сэргээн засах эмчилгээнд хамрагдаагүй, эмнэлгийн хяналтанд ороогүй, хуурамч бичиг баримт бүрдүүлсэн даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хэмжээ, хугацааг тогтоох, сунгахаас татгалзах, цуцлах шийдвэр гаргах;
- 2.5. Шаардлагатай тохиолдолд дахин магадлах, тэтгэврийг түр түдгэлзүүлэх, зогсоох хүртэл арга хэмжээ авах;
- 2.6. Хөдөлмөрийн чадвар алдалтын талаар эрдэм шинжилгээ, судалгааны ажилд оролцох;
- 2.7. Хөдөлмөрийн чадвар алдалтаас урьдчилан сэргийлэх, бууруулах, сэргээн засах үйл ажиллагааг дэмжих;
- 2.8. Эмчилгээ, оношлогооны удирдамжаар хангагдах, мэдлэг мэргэжлээ дээшлүүлэх мэргэжлийн сургалтанд хамрагдахад харьяалах нийгмийн даатгалын байгууллагаас дэмжлэг туслалцаа авах;
- 2.9. Ажлын үр дүнг харгалзан шагнал урамшуулал авах;

Гурав. Магадлагч эмчийн үүрэг

Магадлагч эмч дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

- 3.1. Эмнэлэг хөдөлмөрийн дахин болон бүрдмэл магадлалыг зохион байгуулах, оролцох;
- 3.2. Харьяа хэлтсийнхээ үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус комиссын гишүүнээр ажиллах;
- 3.3. Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын нүүдлийн хурлыг зааврын дагуу зохион байгуулах;
- 3.4. Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын асуудлаар ажил олгогч, даатгуулагч, иргэдээс ирүүлсэн санал, албан бичиг, өргөдөл, гомдол, мэдээллийг хуульд заасан хугацаанд хянан шийдвэрлэх;
- 3.5. “Иргэн (даатгуулагч)-д эмнэлгийн хуудас олгох журам”-ын дагуу эмнэлгийн хуудасны бичилт, олголтод хяналт тавих;
- 3.6. Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын гишүүдийн ажилласан цагийн бүртгэл, тайланг үндэслэн цагийн хөлс, урамшуулал олгох ажлыг зохион байгуулах;
- 3.7. Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын үйлчилгээний чанарыг сайжруулах, ижил мэргэжилтний үзлэг хийх, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор дээд байгууллагын шийдвэрээр сэлгэн ажиллах;
- 3.8. Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадварыг сэргээн засах, эмчлэн эрүүлжүүлэх талаар эрүүл мэндийн байгууллагын зохиож буй үйл ажиллагаанд хяналт тавьж хамтран ажиллах;
- 3.9. “ЭМД-3”, “Health info-3” программаар даатгуулагч (иргэн)-ийн биеийн байдал, оношлогоо, эмчилгээ, сувилгаа хийлгэсэн байдлыг хянах;
- 3.10. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хиймэл эрхтэн, засал эмчилгээ хийлгэсэн байдалд хяналт тавих;
- 3.11. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний сувилалд хяналт шалгалт хийх;
- 3.12. Харьяалах нутаг дэвсгэрийн иргэний бүртгэлийн байгууллагатай хамтран иргэдийн шилжилт хөдөлгөөн, нас баралтын мэдээллийг улирал бүр тулган шалгах;

- 3.13. Хөдөлмөрийн чадвараа хугацаагүйгээр алдсан нь тогтоогдсон даатгуулагч (иргэн)-ийн эрүүл мэндийн байдал, үзүүлж байгаа тусламж, үйлчилгээний талаарх судалгааг харьяалагдах өрх болон сумын эмчээс хагас, бүтэн жилээр авч, хяналт тавьж ажиллах;
- 3.14. Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, эмнэлэг хөдөлмөрийн магадлалын талаар судалгаа, шинжилгээ хийх;
- 3.15. Хөдөлмөрийн чадвар алдалтаас урьдчилан сэргийлэх, бууруулах чиглэлээр орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллага, эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран ажиллах, сургалт зохион байгуулах;
- 3.16. Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолтын байдал, Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын ажлын тайлан, статистик үзүүлэлтүүдэд үнэлэлт, дүгнэлт өгч саналаа Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комисст хүргүүлэх;
- 3.17. Хөдөлмөрийн чадвар алдсан даатгуулагч (иргэн)-ийн эмнэлгийн хувийн хэрэг болон тэтгэврийн хувийн хэргийг Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын мэдээллийн баазтай жилд 2 удаа тулган шалгаж, зөрүүг арилгах арга хэмжээ авч, тайланг ЭХМТК-т жил бүрийн 12 сарын 1-ны өдрийн дотор хүргүүлэх;
- 3.18. Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисстой холбоотой баримт бичиг, тайлангаар архивын нэгж бүрдүүлэн хуулийн хугацаанд багтаан архивт хүлээлгэн өгөх;

Дөрөв. Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

- 4.1. Нийгмийн даатгалын тухай болон холбогдох бусад хууль тогтоомж, энэхүү дүрмийг зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол гэм буруутай этгээдээр учирсан хохирлыг нөхөн төлүүлж, холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ
- 4.2. Хууль тогтоомжид заасан бусад хариуцлага.